**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/130/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит ХХК аудитор: А.Дугармаа<br>Утас: 98904888, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.20 № УВА-2023/130/НП-СНГ-ТШ3
танай______________-ны №________________-т

ЗҮҮНХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.БААСАНДОРЖ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 23,374.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,285.2 мянган төгрөгийн ном хэвлэл, 5,000.0 мянган төгрөгийн газар, ОНХС-ийн хөрөнгөөр 5,643.0 мянган төгрөгийн оффис ширээ, сандал, 14,739.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0200200254

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
Дүгнэлтийн үндэслэл ..... 3
Асуудлыг онцолсон хэсэг ..... 3
Аудитын гол асуудал ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 12
4.1 Ерөнхий зүйл ..... 15
4.2 Материаллаг байдал ..... 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,152,950.20** | **129,443,352.86** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 74,511,201.88 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 74,511,201.88 |
| 3121 | **Төгрөг** | 00.00 | 74,511,201.88 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 74,511,201.88 |
| 33 | **АВЛАГА** | 1,902,406.98 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,902,406.98 | 00.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 62,250,543.22 | 54,932,150.98 |
| 351 | **Түүхий эд материал** | 98,375.00 | 48,596.00 |
| 35130 | Эм боох материал | 98,375.00 | 48,596.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 62,152,168.22 | 54,883,554.98 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,287,930.00 | 2,895,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 38,447,689.33 | 33,286,704.09 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,850,018.01 | 00.01 |
| 35460 | Хүнсний материал | 17,566,530.88 | 18,701,250.88 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,399,758,239.19** | **2,393,865,205.32** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,399,758,239.19 | 2,393,865,205.32 |
| 392 | **Биет хөрөнгө** | 2,299,621,572.48 | 2,289,158,538.57 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,233,859,124.76 | 2,237,859,124.76 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -80,848,583.82 | -117,577,028.67 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,500,000.00 | 28,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28,500,000.00 | -28,500,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 175,874,429.66 | 213,987,429.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -130,970,778.98 | -143,397,511.42 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 88,845,790.53 | 94,488,790.53 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -32,980,114.71 | -39,815,532.61 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 33,656,075.84 | 33,656,075.84 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -21,219,749.44 | -24,733,388.16 |
| 39217 | Ном | 33,405,378.64 | 34,690,578.64 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 100,136,666.71 | 104,706,666.75 |
| 39301 | Програм хангамж | 2,740,000.00 | 2,740,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -873,333.29 | -1,303,333.25 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 98,270,000.00 | 103,270,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,463,911,189.39** | **2,523,308,558.18** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **1,652,625.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 1,652,625.00 |
| 413 | **Өглөг** | 00.00 | 1,652,625.00 |
| 4136 | **Бусад өглөг** | 00.00 | 1,652,625.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 1,652,625.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,463,911,189.39** | **2,521,655,933.18** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,463,911,189.39 | 2,521,655,933.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 418,331,714.20 | 418,331,714.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 418,331,714.20 | 418,331,714.20 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 673,465,665.55 | 731,210,409.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 673,465,665.55 | 673,465,665.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 57,744,743.79 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,372,113,809.64 | 1,372,113,809.64 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,463,911,189.39** | **2,523,308,558.18** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,779,503,636.44** | **1,263,377,246.76** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,774,499,454.44** | **38,541,902.76** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **791,692,554.44** | **38,541,902.76** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 791,692,554.44 | 38,541,902.76 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 2,504,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 2,606,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 790,692,554.44 | 33,431,402.76 |
| **122** | **Тусламжийн орлого** | **181,567,300.00** | **00.00** |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 181,567,300.00 | 00.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **801,239,600.00** | **00.00** |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 801,239,600.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,004,182.00** | **1,224,835,344.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **00.00** | **1,009,693,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,009,693,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,004,182.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,004,182.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 215,141,444.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 215,141,444.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,028,038,277.50** | **1,205,632,502.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,028,038,277.50** | **1,205,632,502.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **993,876,743.06** | **1,158,085,346.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **630,724,007.00** | **717,685,420.52** |
| 210101 | Үндсэн цалин | 420,263,937.69 | 518,381,214.82 |
| 210102 | Нэмэгдэл | 153,232,127.99 | 169,772,579.70 |
| 210104 | Урамшуулал | 40,510,458.23 | 26,171,626.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,717,483.09 | 3,360,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **84,217,137.48** | **90,179,699.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,447,846.16 | 62,286,800.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,417,926.55 | 7,330,475.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,084,329.43 | 5,754,762.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,233,100.63 | 1,345,122.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,033,934.71 | 13,462,538.31 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **171,542,404.10** | **180,576,142.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,360,400.00 | 4,075,278.61 |
| 210302 | Түлш, халаалт | 167,182,004.10 | 176,196,864.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 304,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **17,769,545.00** | **2,793,950.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,168,150.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,772,295.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 572,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,505,000.00 | 83,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,752,100.00 | 2,710,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **26,381,035.00** | **52,522,363.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 975,613.00 | 220,833.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,915,240.00 | 51,647,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,490,182.00 | 653,980.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,893,500.00** | **2,920,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,893,500.00 | 2,920,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 589,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 589,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,141,630.00** | **10,898,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 888,430.00 | 2,612,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 850,000.00 | 8,286,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **57,618,484.48** | **100,509,770.87** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 27,042,557.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,990,204.00 | 13,532,980.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 52,628,280.48 | 59,934,233.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,161,534.44** | **47,547,156.37** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **8,586,734.44** | **1,377,156.37** |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 8,586,734.44 | 1,377,156.37 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,574,800.00** | **46,170,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,473,800.00 | 45,110,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,101,000.00 | 1,060,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **751,465,358.94** | **57,744,743.79** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **7,245,575.73** | **00.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 7,245,575.73 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-7,245,575.73** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **744,219,783.21** | **57,744,743.79** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **988,811,082.00** | **1,229,945,844.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **802,239,600.00** | **5,110,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,000,000.00** | **5,110,500.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,000,000.00** | **5,110,500.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 2,504,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 2,606,300.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **801,239,600.00** | **00.00** |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 801,239,600.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **186,571,482.00** | **1,224,835,344.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 1,009,693,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,009,693,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 181,567,300.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,004,182.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,004,182.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 215,141,444.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 215,141,444.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **988,811,082.00** | **1,132,060,642.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **988,811,082.00** | **1,132,060,642.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **953,309,547.56** | **1,076,926,485.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **633,807,668.33** | **715,785,635.42** |
| 210101 | Үндсэн цалин | 423,835,138.28 | 516,782,462.15 |
| 210102 | Нэмэгдэл | 157,974,404.10 | 169,471,548.87 |
| 210104 | Урамшуулал | 41,920,600.00 | 26,171,624.40 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,077,525.95 | 3,360,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **83,590,090.13** | **90,177,077.62** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,063,725.32 | 62,286,800.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,044,273.33 | 7,330,475.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,804,680.83 | 5,754,762.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,175,775.87 | 1,345,122.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,501,634.78 | 13,459,916.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **171,218,404.10** | **177,690,142.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,360,400.00 | 4,075,278.61 |
| 210302 | Түлш, халаалт | 166,822,004.10 | 173,316,864.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,000.00 | 298,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,424,575.00** | **00.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,095,080.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,772,295.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 572,000.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 497,900.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,575,600.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,911,700.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **37,254,080.00** | **44,135,270.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 395,780.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 35,368,300.00 | 44,135,270.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,490,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,959,600.00** | **2,500,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,700,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,259,600.00 | 2,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 589,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 589,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,141,630.00** | **10,790,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 888,430.00 | 2,504,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 850,000.00 | 8,286,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,324,500.00 | 35,848,160.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 24,413,110.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,324,500.00 | 11,435,050.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,501,534.44** | **55,134,156.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **26,914,800.00** | **53,757,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,473,800.00 | 53,757,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,441,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,586,734.44 | 1,377,156.37 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,586,734.44 | 1,377,156.37 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **97,885,201.88** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **23,374,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **23,374,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 23,374,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 23,374,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-23,374,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 74,511,201.88 |
| **9** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| **10** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 74,511,201.88 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 418,331,714.20 | 1,380,844,347.25 | -129,662,108.60 | 00.00 | 1,669,513,952.85 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **418,331,714.20** | **1,380,844,347.25** | **-129,662,108.60** | **00.00** | **1,669,513,952.85** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 30,830,862.05 | 00.00 | 30,830,862.05 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,331,714.20** | **1,372,113,809.64** | **673,465,665.55** | **00.00** | **2,463,911,189.39** |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **418,331,714.20** | **1,372,113,809.64** | **673,465,665.55** | **00.00** | **2,463,911,189.39** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **418,331,714.20** | **1,372,113,809.64** | **673,465,665.55** | **00.00** | **2,463,911,189.39** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 57,744,743.79 | 00.00 | 57,744,743.79 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,331,714.20** | **1,372,113,809.64** | **731,210,409.34** | **00.00** | **2,521,655,933.18** |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,014,804,400.00** | **940,293,198.12** | **74,511,201.88** | **93%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,014,804,400.00** | **940,293,198.12** | **74,511,201.88** | **93%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **955,358,900.00** | **886,536,198.12** | **68,822,701.88** | **93%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **733,370,900.00** | **685,974,908.25** | **47,395,991.75** | **94%** |
| 210101 | Үндсэн цалин | 540,756,000.00 | 494,229,242.98 | 46,526,757.02 | 91% |
| 210102 | Нэмэгдэл | 184,877,700.00 | 167,585,409.87 | 17,292,290.13 | 91% |
| 210104 | Урамшуулал | 7,737,200.00 | 24,160,255.40 | -16,423,055.40 | 312% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **91,671,100.00** | **86,413,659.87** | **5,257,440.13** | **94%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,336,500.00 | 59,610,082.07 | 2,726,417.93 | 96% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,333,600.00 | 7,012,946.21 | 320,653.79 | 96% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,866,900.00 | 5,516,277.12 | 350,622.88 | 94% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,466,700.00 | 1,296,640.44 | 170,059.56 | 88% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,667,400.00 | 12,977,714.03 | 1,689,685.97 | 88% |
| **2105** | **Нормативт зардал** | **44,236,800.00** | **44,135,270.00** | **101,530.00** | **100%** |
| 210502 | Хоол, хүнс | 44,236,800.00 | 44,135,270.00 | 101,530.00 | 100% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,880,100.00** | **10,790,200.00** | **89,900.00** | **99%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,504,200.00 | 2,504,200.00 | 0.00 | 100% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,375,900.00 | 8,286,000.00 | 89,900.00 | 99% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **75,200,000.00** | **59,222,160.00** | **15,977,840.00** | **79%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,636,100.00 | 47,787,110.00 | 14,848,990.00 | 76% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,563,900.00 | 11,435,050.00 | 1,128,850.00 | 91% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,445,500.00** | **53,757,000.00** | **5,688,500.00** | **90%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **59,445,500.00** | **53,757,000.00** | **5,688,500.00** | **90%** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 59,445,500.00 | 53,757,000.00 | 5,688,500.00 | 90% |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,014,804,400.00** | **1,014,804,400.00** | **0.00** | **100%** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,009,693,900.00** | **1,009,693,900.00** | **0.00** | **100%** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,009,693,900.00 | 1,009,693,900.00 | 0.00 | 100% |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **5,110,500.00** | **5,110,500.00** | **0.00** | **100%** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,504,200.00 | 2,504,200.00 | 0.00 | 100% |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,606,300.00 | 2,606,300.00 | 0.00 | 100% |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 73,134,045.51 | -73,134,045.51 | |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **215,141,700.00** | **213,764,287.63** | **1,377,412.37** | **99%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **215,141,700.00** | **213,764,287.63** | **1,377,412.37** | **99%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **215,141,700.00** | **213,764,287.63** | **1,377,412.37** | **99%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **29,810,800.00** | **29,810,727.17** | **72.83** | **100%** |
| 210101 | Үндсэн цалин | 26,450,800.00 | 22,553,219.17 | 3,897,580.83 | 85% |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 1,886,139.00 | -1,886,139.00 | |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 2,011,369.00 | -2,011,369.00 | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,360,000.00 | 3,360,000.00 | 0.00 | 100% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,763,600.00** | **3,763,417.75** | **182.25** | **100%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,676,800.00 | 2,676,717.97 | 82.03 | 100% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 317,500.00 | 317,529.14 | -29.14 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 238,500.00 | 238,485.79 | 14.21 | 100% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 48,500.00 | 48,482.44 | 17.56 | 100% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 482,300.00 | 482,202.41 | 97.59 | 100% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **179,067,300.00** | **177,690,142.71** | **1,377,157.29** | **99%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,450,000.00 | 4,075,278.61 | 1,374,721.39 | 75% |
| 210302 | Түлш, халаалт | 173,317,300.00 | 173,316,864.10 | 435.90 | 100% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 298,000.00 | 2,000.00 | 99% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,500,000.00** | **2,500,000.00** | **0.00** | **100%** |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100% |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **215,141,700.00** | **215,141,444.00** | **256.00** | **100%** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **215,141,700.00** | **215,141,444.00** | **256.00** | **100%** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 215,141,700.00 | 215,141,444.00 | 256.00 | 100% |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **26.00** | **26.00** | **0.00** | **100%** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **13.00** | **13.00** | **0.00** | **100%** |
| 620004 | Гэрээт ажилтан | 13.00 | 13.00 | 0.00 | 100% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **13.00** | **13.00** | **0.00** | **100%** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11.00 | 11.00 | 0.00 | 100% |
| 650010 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 | 0.00 | 100% |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь төсвийн хөрөнгийг нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай зарцуулдаг байдлыг хангуулах үйл ажиллагаа явуулдаг юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,397.3 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 74,511.2 | 74,511.2 |
| Авлага | 1,902.4 | 0.0 | -1,902.4 |
| Бараа материал | 62,250.5 | 54,932.1 | -7,318.2 |
| Үндсэн хөрөнгө | 2,399,758.2 | 2,393,865.2 | -5,893.0 |
| **Нийт хөрөнгө** | **2,463,911.1** | **2,523,308.5** | **59,397.3** |
| Өр төлбөр | 0.0 | 1,652.6 | 1,652.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,463,911.1 | 2,521,655.9 | 57,744.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,463,911.1** | **2,523,308.5** | **59,397.4** |

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 74,511.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны цалингийн ашиг болон нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1,902.4 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54,932.1 мянган төгрөг болж 7,318.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал зарцуулсан шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,393,865.2 мянган төгрөг болж 5,893.0 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардал өссөн шалтгаалжээ.

Өглөг 1,652.6 мянган төгрөг болж нэмэгдсэн нь дулааны төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,521,655.9 мянган төгрөг болж 57,744.7 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,223,625.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас боловсролын стандарт сургалтын үйл ажиллагааны /80134/ зардлыг 6,320.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,229,945,8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,229,945.8 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,229,945.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,154,057.5 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 75,888.3 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын үйлчилгээ /80226/ | 3,350.4 | 3,350.4 | 0.0 | 100% |
| 2 | Сургалт семинар /80312/ | 1,675.2 | 978.7 | 696.5 | 58.4% |
| 3 | Эрүүл мэндийг дэмжих /81605/ | 3,852.9 | 3,847.0 | 5.9 | 99.8% |
| 4 | Үдийн цай хөтөлбөр /81801/ | 59,445.5 | 53,757.0 | 5,688.5 | 90.4% |
| 5 | Дотуур байрны үйлчилгээ /81806/ | 61,161.9 | 58,947.2 | 2,214.7 | 96.3% |
| 6 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/ | 37,465.0 | 23,374.0 | 14,091.0 | 62.4% |
| 7 | Боловсролын байгууллагыг багш, ажилчдын хөгжил /81823/ | 7,538.3 | 7,483.5 | 54.8 | 99.7% |
| 8 | Боловсролын стандарт, сургалт /81834/ | 754,808,0 | 709,963.9 | 44,844.1 | 94.1% |
| 9 | Сургалтын хэвийн үйл, ажиллагаа /81835/ | 80,396.7 | 73,248.0 | 6,915.7 | 91.1% |
| 10 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт-ОН | 215,141.4 | 213,764.3 | 1,377.1 | 99.35% |
| 11 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/ | 181,567.3 | 180,190.2 | 1,377.1 | 99.2% |
| 12 | Нийтлэг үйлчилгээний зардал /80112/ | 33,574.4 | 33,574.4 | 0.0 | 100% |
| 13 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,504.2 | 2,504.2 | 0.0 | 100% |
| 14 | Сурах бичгийн түрээс /81848/ | 2,504.2 | 2,504.2 | 0.0 | 100% |
| 15 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,606.3 | 2,606.3 | 0.0 | 100% |
| 16 | Дээд шатны төсвөөс хуваарилагдсан /83603/ | 2,606.3 | 2,606.3 | 0.0 | 100% |

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь албан хаагчид өвчтэй, цалингүй чөлөөтэй байсан зэргээс шалтгаалан 47,396.0 мянга, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5,257.6 мянга, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,377.1 мянга, Норматив зардал 101.5 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 89.9 мянга, Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 5,688.5 мянга, Бараа үйлчилгээний бусад зардал 15,977.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Зүүнхангай сумын

Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,205.6 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,205.6 сая төгрөгийн 0.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр 80 хувиар тооцож 4.8 сая төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 145, хугацаа хоцроож 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь Зөрчлийн утгыг оруулах Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК-ийн АУДИТОР /А.ДУГАРМАА/

2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр